"Иргэний нисэхийн үндэсний төв" ТӨХХК-ийн
Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 06 дугаар
сарын 12-ны өдрийн 20/26 дугаар тогтоол

ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 1. АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЧАНАРЫН УДИРДЛАГЫН СТРАТЕГИ

ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 2. КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ, ХҮНИЙ НӨӨЦИЙН УДИРДЛАГЫН СТРАТЕГИ

ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 3. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР АШИГ, ХҮЧИН ЧАДАЛ, ХҮРТЭЭМЖ НЭМЭГДҮҮЛЭХ СТРАТЕГИ

ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 4. ТЕХНИК, ТЕХНОЛОГИЙН ШИНЭЧЛЭЛИЙН СТРАТЕГИ

ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 5. САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН СТРАТЕГИ

ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 1. АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЧАНАРЫН УДИРДЛАГЫН СТРАТЕГИ - Аюулгүй байдал, чанарын удирдлагын соёлыг төлөвшүүлж, тасралтгүй сайжруулна.

Олон улсын стандарт, жишигт нийцсэн баримт бичгийн тогтолцоо, мэргэшсэн хүний нөөц, найдвартай техник, технологи ашиглан нисэхийн аюулгүй байдлын түвшнийг тогтвортой хангаж, компанийн үйл ажиллагааны чанарыг тасралтгүй сайжруулах зорилгоор дараах зорилтуудыг дэвшүүлж байна. Үүнд:

Зорилт 1.1 Үйл ажиллагааны аюулгүй байдал, чанарын удирдлагын нэгдсэн тогтолцоог сайжруулна.

Зорилт 1.2 Аюулгүй байдлын соёл, хандлага, мэдээлэх тогтолцоог төлөвшүүлнэ.

ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 2. КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ, ХҮНИЙ НӨӨЦИЙН УДИРДЛАГЫН СТРАТЕГИ - Мэдлэг, ур чадвартай хүний нөөцийн менежментийг хэрэгжүүлнэ.

Компанийн хүний нөөц, мэдээллийн системийн чадавхыг оновчтой удирдах замаар байгууллагын тогтвортой, үр ашигтай үйл ажиллагааг хангана. Мөн компанийн бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгож, чиг үүрэг, эрх мэдэл, хариуцлагын тогтолцоог сайжруулах замаар засаглалын чадавхыг бэхжүүлнэ. Удирдлагын ил тод, үр ашигтай, мэдээлэлд суурилсан шийдвэр гаргалт бүхий менежментийн тогтолцоог бүрдүүлнэ.

Хүний нөөцийн чадавх, эрүүл мэнд, ажиллах нөхцөл, карьер хөгжлийг судалгаанд үндэслэн төлөвлөх, тогтвортой, шударга, өрсөлдөөнт тогтолцоог бүрдүүлж, урамшуулал, нийгмийн баталгааг дэмжсэн бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор дараах зорилтуудыг дэвшүүлж байна. Үүнд:

Зорилт 2.1 Компанийн сайн засаглалын тогтолцоог хөгжүүлнэ.

Зорилт 2.2 Чадавхад суурилсан хүний нөөцийн тогтолцоог бүрдүүлнэ.

Зорилт 2.3 Ажилтнуудын нийгмийн баталгааг хангаж, ажиллах таатай орчныг бий болгоно.

ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 3. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР АШИГ, ХҮЧИН ЧАДАЛ, ХҮРТЭЭМЖ НЭМЭГДҮҮЛЭХ СТРАТЕГИ - Үйлчилгээний хүртээмж, хүчин чадлыг нэмэгдүүлж, аюулгүй, найдвартай, тогтвортой үйл ажиллагааг хангана.

Компанийн үйл ажиллагааг илүү оновчтой, тасралтгүй, хүртээмжтэй болгож хүчин чадлыг сайжруулах замаар эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор дараах зорилтуудыг дэвшүүлж байна. Үүнд:

Зорилт 3.1 Үйлчилгээний эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлнэ.

Зорилт 3.2 Үйлчилгээний хүчин чадал, хүртээмжийг нэмэгдүүлнэ.

Зорилт 3.3 Төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх, эко үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.

ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 4. ТЕХНИК, ТЕХНОЛОГИЙН ШИНЭЧЛЭЛИЙН СТРАТЕГИ - Агаарын тээврийн тасралтгүй, найдвартай ажиллагааг хангасан дэвшилтэт техник, технологийг ашиглана.

Агаарын тээврийн тасралтгүй, найдвартай ажиллагааг хангах зорилгоор систем, тоног төхөөрөмжийг үе шаттайгаар шинэчлэх, олон улсын дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх, үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд инновац, дижитал шилжилтийг эрчимжүүлэх замаар үйлчилгээний хүчин чадал, үр ашиг, бүтээмжийг нэмэгдүүлэх зорилгоор дараах зорилтуудыг дэвшүүлж байна. Үүнд:

Зорилт 4.1 Насжилт өндөртэй тоног төхөөрөмж, техник хэрэгслийг шинэчилнэ.

Зорилт 4.2 Нисэхийн үндсэн үйлчилгээнд олон улсын тэргүүлэх техник, технологи нэвтрүүлнэ.

Зорилт 4.3 Инновац нэвтрүүлэх, дижитал шилжилтийг эрчимжүүлнэ.

ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 5. САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН СТРАТЕГИ - Орлого нэмэгдүүлж, зардлыг бууруулж, хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлнэ.

Нисэхийн аюулгүй байдлыг хангаж ажиллахын зэрэгцээ үндсэн болон дэмжих үйлчилгээнүүдийн тасралтгүй, найдвартай ажиллагааг хангах тоног төхөөрөмжийн цогц шинэчлэл хийх, хүний нөөцийг хангалттай түвшинд бэлтгэх, дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх хэрэгцээ шаардлага үүсээд байна.

Иймд орлогын эх үүсвэрийг төрөлжүүлж, зардлыг оновчтой удирдах замаар үйл ажиллагааны үр ашиг, орлого, зардлын зохистой тэнцвэрийг хангах үр ашигт чиглэсэн хөрөнгө оруулалтын тогтолцоог бий болгож, эрсдэл багатай, хяналттай санхүүгийн удирдлагыг хэрэгжүүлэх зорилгоор дараах зорилтуудыг дэвшүүлж байна. Үүнд:

Зорилт 5.1 Орлого, зардлын бүтцийг оновчтой болгоно.

Зорилт 5.2 Үр ашигт чиглэсэн хөрөнгө оруулалтын тогтолцоог бий болгож өгөөжийг нэмэгдүүлнэ.

Дэлгэрэнгүй мэдээлэл авах эх сурвалж:
Стратеги төлөвлөлтийн газар
Мэргэжилтэн
О.Хайриймаа
Утас: 71283333
Имэйл: khairiimaa.o@ncac.mn